

БАТЛАВ.  
БАРИЛГА, ХОТ  
БАЙГУУЛАЛТЫН САЙД

Х.БАДЕЛХАН

БАТЛАВ.  
МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

БАТЛАВ.  
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД  
ХЭРГИЙН САЙД

Ц.НЯМДОРЖ

## ОРОН ЗАЙН ӨГӨГДЛИЙН ДЭД БУТЦИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

**Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага**

### 1.1.Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ын Дэд бутцийн салбарыг хөгжүүлэх 5 дугаар зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд “...үндэсний орон зайн мэдээллийн дэд бутцийг байгуулах...” гэж, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 121 дүгээр тогтоолоор баталсан “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний 2.80.5 дахь заалтад “Орон зайн өгөгдлийн дэд бутцийн тухай хуулийн төслийг боловсруулна.” гэж заасан.

Түүнчлэн Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 47 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого /2017-2025/-ын баримт бичиг”-ийн 3.4.8 дахь заалтад “гео-орон зайн мэдээллийн дэд бутцийг ашиглан төрийн байгууллага, иргэдэд үнэн зөв, нарийвчлалтай мэдээлэлд үндэслэсэн орон зайн дүн шинжилгээ, ухаалаг төлөвлөлт хийх боломжийг бүрдүүлнэ.” гэж заасан.

### 1.2.Практик шаардлага

Мэдээллийн технологийн салбар эрчимтэй хөгжихийн хирээр орон зайн мэдээллийг агуулсан тоон өгөгдлийн хэрэглээ өсч, түүнд тулгуурласан мэдээллийн нэгдсэн систем үүсгэж нийтийн болон албан хэрэглээнд нэвтрүүлэх, ашиглах, утас, түүнтэй адилтгах төхөөрөмж ашиглан төрөл бүрийн контент хөгжүүлэх, хэрэглэх хэрэгцээ, шаардлага үүсээд байна.

Олон улсад орон зайн өгөгдөл, мэдээллийг улс орны бүтээн байгуулалт, дэд бутцийн төлөвлөлт, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, эдийн засаг, нийгмийн гол хүчин зүйлсийг урьдчилан тооцоолох, төлөвлөх болон гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг нь арилгах зэрэг үйл ажиллагаанд нэгдсэн платформоор дамжуулан ашигладаг. Мөн орон зайн өгөгдөл, мэдээллийг статистикийн болон бусад төрлийн тоон мэдээлэлтэй нэгтгэн анализ хийж, бизнесийн болон төрийн үйлчилгээний шинэ санааг хэрэгжүүлэн үр ашгийг нь хүртэж байна.

Орон зайн өгөгдлийн дэд бутцийг 1990 оноос хойш 100 гаруй улсад байгуулсан байгаа бөгөөд АНУ, Австрали болон Европын ихэнх улс орнууд үндэсний орон зайн өгөгдлийн дэд бутцийн үзэл баримтлалыг боловсруулахаас эхлээд тэдгээрийг бүрдүүлэх, хөгжүүлэх чиглэлээр бүхий л үе шатны төсөл, хөтөлбөрүүдийг бүрэн хэрэгжүүлж дуусгасан байна. Дээрх орнуудын хувьд иргэд, олон нийтийн байгууллагууд

болон төрийн захиргааны байгууллагуудад орон зайн өгөгдөл, мэдээллийг чөлөөтэй хайх, хандах, хэрэглэх боломж бүрдсэн төдийгүй байрлалд сууринсан мэдээллийн хэрэглээнээс байгаль, нийгэм, эдийн засгийн үр өгөөж хүртэж эхэлсэн байна. Өнөөдөр хамгийн шинэлэг шийдэл, тэсрэлт хийсэн бизнес загварууд хөгжих, хэрэглээнд нэвтрэхэд байрлалд сууринсан мэдээллийн аналитик шинжилгээ үндсэн гол хөшүүрэг нь болж байна.

Орон зайн өгөгдлийн дэд бүтэц гэдэг нь орон зайн өгөгдөл, мэдээллийг бүрдүүлэгч, хэрэглэгч болон тэдгээрийн хамтын ажиллагааг удирдан зохион байгуулах үйл ажиллагаа, бодлого, хууль, эрх зүй, стандарт, техник, технологи, хүний нөөцийн цогцыг хэлэх бөгөөд байгууллагууд хаана байрлаж, ямар чиг үүрэг эрхлэхээс үл хамааран нэг удаа бүрдүүлсэн мэдээллийг төрөл бүрийн зорилгоор олон удаа ашиглах, шинэчлэх боломжийг бий болгоход оршино.

Өнөөдөр орон зайн өгөгдөл, мэдээллийг бүрдүүлэх, ашиглахтай холбоотой асуудлыг зохицуулсан хүчин төгөлдөр үйлчилж буй 13 хуульд давхардсан тоогоор 44 мэдээллийн сангийн талаар тодорхой зохицуулалт байгаа боловч тэдгээр мэдээллийн сангидын хоорондын уялдааг хангах, орон зайд дурслэгдэх өгөгдөл, мэдээлэлд сууринсан мэдээллийн нэгдсэн системийг бий болгох, орон зайн өгөгдөл, мэдээллийн нэгдмэл байдлыг хангахтай холбоотой эрх зүйн зохицуулалт байхгүй байна.

Монгол Улсад байрлалд сууринсан орон зайн өгөгдөл, мэдээллийг агуулсан мэдээллийн сан нь тухайн нэг салбар, байгууллагын хэрэгцээг хангах төдий хэмжээнд байгаа бөгөөд төрийн захиргааны төв байгууллагуудаас авсан судалгааны үр дүнгээс харахад орон зайн мэдээллийн сангийн хэлбэр нь хүснэгтэн, зурган хэлбэрээр байхаас гадна орон зайн өгөгдлийн сангийн удирдах системд ороогүй, хоорондоо уялдаагүй, нийцээгүй байна. Төрийн байгууллагууд хоорондоо албан бичгээр, цаасан хэлбэрээр орон зайн мэдээллээ солилцсоор байгаа нь цагийг үр бүтээлтэй ашиглаж, ажиллах боломж нөхцөлийг бүрдүүлэхэд саад учруулж байна.

Орон зайн өгөгдөл, мэдээллийн нэгдсэн систем байхгүй байгаа нь салбар бүрт төрөл бүрийн орон зайн өгөгдлийг тус тусдаа бүрдүүлэх, давхардсан хөрөнгө оруулалтаар үргүй зардал гаргах, шийдвэрүүд нэгдсэн зохицуулалтгүй, мэдээллийн нэгдмэл, давтагдашгүй, нээлттэй, алдаагүй, шинэлэг байх зарчим алдагдах нөхцөлийг үүсгэж байна.

Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн суурь өгөгдөл тодорхойгүй байгаагаас гадна байр зүй, хаяг, кадастр, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хилийн цэсийн зураг нь нэгдсэн стандартын дагуу нийтийн хэрэгцээнд гарахгүй байгаа нь дэлхийн байрлал тодорхойлох тогтолцоо (GPS)-ны болон авто замын навигацийн, байрлалд сууринсан төрөл бүрийн хайлтын, онлайн үйлчилгээний бизнесийн орчин хөгжих нөхцөлийг хязгаарлаж байна.

Орон зайн өгөгдөл, мэдээлэлтэй холбоотой үндэсний 2 стандарт (Газар зүйн мэдээлэл-Мета өгөгдөл MNS 5774:2007, Газар зүйн мэдээлэл – Нэр томьёо MNS-ISO-TC-19104:2012) мөрдөгдөж байгаа боловч орон зайн өгөгдөл, мэдээллийг бүрдүүлэх, боловсруулах, хадгалах, хамгаалах, түгээх, хэрэглэх үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангахтай холбоотой стандартыг мөрдүүлэх эрх зүйн орчин бүрдээгүй байна.

Олон улсын туршлагаас үзэхэд орон зайн мэдээллийг хэрэглүүлэх, ашиглуулах, түгээх, солилцох зэрэг үйл ажиллагаанд орон зайн мэдээллийн “лиценз” гэсэн нэр томьёог хэрэглэж байна. Лиценз нь орон зайн өгөгдөл, мэдээллийг хэрэглэгч болон түгээгчийн хооронд үүсэх асуудлыг зохицуулах бөгөөд иргэн, хуулийн этгээд нь нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох, аж ахуй эрхлэхэд ашигтай санаа, инновацийг хөгжүүлэх, дэмжихэд чухал үүрэгтэй төдийгүй хэрэглэгчдэд чирэгдэлгүй, шуурхай, чанартай үйлчилгээ үзүүлэх ач холбогдолтой.

Иймд дээрх үндэслэл, шаардлагын үүднээс орон зайн өгөгдөл, мэдээллийг бүрдүүлэх, боловсруулах, хадгалах, хамгаалах, түгээх, хэрэглэх, үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, хяналт тавих, орон зайн өгөгдөл, мэдээллийг бүрдүүлэгч, хэрэглэгчийн хамтын ажиллагааг зохицуулах, төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай, чирэгдэлгүй хүргэх нөхцөлийг бүрдүүлэх, төсвийн үргүй зардал, давхардсан хөрөнгө оруулалтыг арилгах зорилгоор Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн талаарх хууль, эрх зүйн орчныг бий болгох зайлшгүй шаардлагатай байна.

### **Хоёр.Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Хуулийн төсөл нь Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай гэсэн нэртэй байх бөгөөд уг хуулиар дор дурдсан харилцааг зохицуулна:

1.Орон зайн өгөгдлийн дэд бүтэц, түүний үйл ажиллагааны зарчим, нэр томъёоны тодорхойлолт, өгөгдөл, мэдээллийн ангилал, тэдгээрийн бүрдүүлэлт, боловсруулалтын үйл ажиллагааны талаар тусгана.

2.Орон зайн өгөгдөл, мэдээллийг бүрдүүлэлт, боловсруулалт, хадгалаалт, хамгаалалт, хэрэглээ, түгээлтийн стандартын нэгдсэн тогтолцоо, мэдээллийг бүрдүүлэгч, хэрэглэгчийн хоорондын мэдээлэл ашиглах, ашиглуулах нөхцөл, мэдээллийн аюулгүй байдлыг хэрхэн хангах талаар болон нууцлах шаардлагатай мэдээллийн талаар тусгана.

3.Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах этгээд, тэдгээрийн эрх, үүргийг тодорхойлж, өгөгдлийн сангудын нэгдмэл байдлыг хангах зохицуулалтыг тусгана.

4.Орон зайн өгөгдөл, мэдээллийг бүрдүүлэгч, хэрэглэгчийн хамтын ажиллагаа, түншлэлийн харилцааг зохицуулна. Тухайлбал, орон зайн өгөгдлийн дэд бүтцийн үйл ажиллагааг эрхлэхтэй холбогдсон иргэн, хуулийн этгээд, төрийн болон эрх, үүрэг тодорхой болж бүх салбарт орон зайн мэдээллийн үр дүнтэй хэрэглээг нэмэгдүүлнэ.

5.Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн үйл ажиллагааг дэмжих, хөгжүүлэх бодлого, хөтөлбөр гаргах талаар болон хүний нөөцийн асуудлын талаарх зохицуулалтыг тусгана.

6.Орон зайн өгөгдөл, мэдээллийг нэгдмэл байдлаар ашиглах, удирдах боломж бүхий орон зайн өгөгдлийн дэд бүтцийг байгуулах, хэрэгжүүлэх, удирдан зохион байгуулах, хяналт тавих, хориглох үйл ажиллагаа болон хариуцлагатай холбогдсон харилцааг тусгана.

### **Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал:**

Хуулийн төсөл батлагдсанаар эдийн засаг, нийгмийн дараах үр дагавар бий болно. Үүнд:

1.Байгаль орчин, дэд бүтцийн салбарын орон зайн өгөгдөл, мэдээллийг нэгдсэн удирдлага, стандартаар хангаж, байгууллага хоорондын хамтын ажиллагаа, харилцан уялдааг сайжруулж, орон зайн өгөгдөл, мэдээллийг нийтэд нээлттэй, хүртээмжтэй түгээх болон шинэлэг агуулга бүхий нэгдмэл, үнэн зөв өгөгдөл, мэдээллийг ашиглахтай холбоотой асуудал тодорхой болно.

2.Орон зайн өгөгдөл, мэдээллийг бүрдүүлэх, боловсруулах, хадгалах, хамгаалах, түгээхэд зарцуулагдаж буй давхардсан зардлууд арилж, байгууллага хоорондын үйл ажиллагааны уялдаа боловсронгуй болж, өгөгдөл, мэдээллийг нэгдсэн загвар, стандартын дагуу бүрдүүлэх, ашиглах, түгээх нэгдсэн тогтолцоо бүрдэнэ. Түүнчлэн тус тогтолцоог бүрдүүлэхэд программ хангамж, компьютер, техник хэрэгсэл

зэрэг орон зайн мэдээллийн технологийн чадавхыг сайжруулах шаардлагатай тодорхой хэмжээний төсөв шаардагдана.

3. Орон зайн өгөгдлийн дэд бүтэц нь төрийн үйлчилгээний нэг хэсэг тул цаашид “Цахим засаглал”-ыг байрлалд сууринсан төрөл бүрийн өгөгдөл, мэдээллээр дэмжих төдийгүй бүх салбарын орон зайн өгөгдөл, мэдээллийг нэг цэгээр дамжуулан төрийн үйлчилгээг иргэдэд түргэн, шуурхай хүргэх боломжийг нэмэгдүүлнэ.

4. Байгалийн гамшиг, онцгой байдал, хот төлөвлөлт, дэд бүтцийн төлөвлөлтөд нэгдсэн нэг үүсвэрээс суурь орон зайн өгөгдөл, мэдээлэл авах нөхцөл бүрдэж, статистикийн болон бусад төрлийн мэдээлэлтэй давхцуулан тодорхой зорилго бүхий нэмүү өртөг шингээсэн мэдээлэл гарган авах, ашиг олох, бизнесийн салбарууд өргөжих нөхцөл, боломжууд бүрдэнэ.

**Дөрөв. Хуулийн төсөл нь бусад хуультай хэрхэн уялдах, уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаар**

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуульд нийцэх бөгөөд хуулийн төсөлтэй холбогдуулан Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулна.

---оо---